

ТӨВСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 5/7

Баянтал сум

1-р багийн Засаг даргын түр орлон гүйцэтгэгчээс
чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захирагаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, Захирагааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулагын 79 дүгээр зүйлийн 79.1, Төрийн албаны тусламжийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.2.4, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 166 дугаар тушаал “Ээлжийн амралтын олговор тооцэх журам”-ын заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн шалтгааны улмаас ажлаас чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн 1-р багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Нэргүй овогтой Мөнгөнцэцэгийг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. Ажил хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу ажил хүлээлцэхийг комисст үүрэг болгосугай.

Комиссын дарга:

Л.Отгонпүрэв

(Санхүү албаны дарга)

Гишүүн:

Н.Сарантuya

(Аж ахуйн нярав)

Нарийн бичгийн дарга:


Э.Буянтогтох

(Нийгмийн бодлого хавсрлан

гүйцэтгэгч)

3. Н.Мөнгөнцэцэгтэй холбогдох тосцоог хийж дуусгахыг Санхүү албаны ерөнхий нягтлан бодогч (Х.Ариунгүа)-д үүрэг болгосугай.

ДАР ГАНХБАЯР



ГӨВСТМЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 5/63

Баянтал сум

1-р багийн Засаг даргын албан тушаалд
томилох тухай

Монгол улсын засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5, 59 дүгээр зүйлийн 59.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Улсын Их Хурлын 2007 оны “Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нэхцлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 73 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоол, сумын Иргэдний нийтийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “1-р багийн Засаг даргаар сонсох тухай” хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны Багийн Засаг даргын сонгуулийн үр дүнгээр соногдсон, 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 05/8732 тоот албан бичгээр Хувийн ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй Эрдэнэ овогтой Түмэн-Эрдэнийг Баянтал сумын 1-р багийн Засаг даргаар 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ажил хүлээнлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, зохих журмын дагуу ажил хүлээнлэхийг комисст үүрэг болгосугай.

Комиссын дарга: Л.Отгонпүрэв (Санхүү албаны дарга)

Гишүүн: Н.Сарантуяа (Аж ахуйн нярав)

Нарийн бичгийн дарга: Э.Буяントгох (Нийгмийн бодлого хавсрсан
гүйцэтгэгч)

2. Э.Түмэн-Эрдэнэд албан тушаалын сарын үндсэн цалинг 697,388 /зургаан зуун ерэн долоо мянга турван зуун наян найм/ төгрөгөөр, Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нэхцлийн нэмэгдлийг албан тушаалын сарын цалингийн 30 хувиар тооцож олгож байхыг Санхүү албаны нягтлан бс дочгч /Х.Ариунгуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Э.Түмэн-Эрдэнэд томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ харьяа Эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгөх үүрэгтэй сануулсугай.

4. Э.Түмэн-Эрдэнэд багийн Засаг даргын ажлын байрны тодорхойлолтод заагчсан чиг үүрэг болон ажилдаа хариуцлагатай хандаж, хууль тогтоомжийг чанд сахиж, төрийн албан хаагчийн ёс зүйг мөрдэж, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үргээ биелүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА ГАНХБАЯР